



**МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/217

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам"-ын дагуу их, дээд сургуульд оюутан элсүүлэх ажлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Дарга	С.Мөнхцэцэг	-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Гишүүд:	Н.Хүрэлээ	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
	Д.Өнөрцэцэг	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Я.Батбилэгт	-Боловсрол, соёл, урлагийн газрын ахлах мэргэжилтэн
	П.Ариунбаатар	-Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн
	С.Дөлгөөн	-Тагнуулын хэлтсийн ажилтан
	Ю.Цэцэгмаа	-Цагдаагийн дэслэгч
Нарийн бичгийн дарга:	Ө.Буяндэлгэр	-Цагдаагийн дэд ахлагч
	Э.Болормаа	-Боловсрол, соёл, урлагийн газрын ахлах мэргэжилтэн

2. Элсэлтийн үйл явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч Б.Отгонцолмонд, зохион байгуулалтын ажлыг журмын дагуу, өндөр түвшинд гүйцэтгэхийг ажлын хэсэг /С.Мөнхцэцэг/-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА